

ЯПОНЫ УЛС ТӨРИЙН ТОГТОЛЦООНЫ УЛАМЖЛАЛ ШИНЭЧЛЭЛ

*У.Загдцэсэм**

Дэлхийн түүхэнд эртний төрт улсын тоонд багтдаг орны нэг нь Япон улс юм. МЭ-ний IV зууны дунд үед Японы нутаг дэвсгэр дээрх хэд хэдэн улс аймгийг эрхшээлдээ оруулсан Ямато улс хэдийнээ байгуулагдаад байв. Хөгжлийн явдал төрийн тогтолцоог боловсронгуй болгох шаардлага аяндаа бий болж, түүнийг хэрэгжүүлсэн нь Шёотоку хунтайж юм. VII зууны эхээр хунтайж Шёотоку улс төрийн шинэчлэл явуулсан бөгөөд түүнийг Тайка-но какушин¹ буюу Тайкагийн шинэчлэл гэдэг. Шинэчлэлийн гол зорилго нь үндсэн хууль гаргах явдал байв. Шёотоку хунтайж 17 зүйл бүхий үндсэн хууль боловсруулж хэрэгжүүлсэн байна. Түүгээрээ Япон улс Азид хамгийн эртний Үндсэн хуультай улс болсон гэгддэг.

710 онд улс төрийн төв Нара хотод төвлөрч, Японы анхны нийслэл хот байгуулагдав. VIII зууны үед сурвалжит язгууртан Фүживара засгийн эрхийг гартаа авч одоогийн Кёото хотод нийслэлийг шилжүүлэн, улс төрийн хэргийг удирдан явуулах болсон байна.

1192 онд Минамото Ёритомо нь Камакүрадцэргийн засгийн газар “бакүфү”-г байгуулсан бөгөөд эзэн хаан түүнд “шёогүн” цол хүртээжээ. Бакүфү гэдэг нь цэрэг язгууртнуудын засгийн газар бөгөөд засгийн эрх барих эрхийг эхний үед эзэн хаанаас олгодог байжээ. Аажмаар эзэн хааныг төрийн хэргээс холдуулж, засгийн эрхийг шёогүн хамаарах болсон байна. Тийнхүү Япон улсын түүхэнд 1192 онд Бакүфү засгийн газар байгуулагдаж 1868 оныг хүртэл оршин тогтножээ. Шёогүн засгийн эрхийг барих хугацаанд түүхийн зарим үе түүний эрх мэдэл бэхжиж, зарим үе буурч ирсэн байна.

Япон гадны улсын довтолгоонд тэр болгон өртдөггүй, газар зүйн байршлаас далай тэнгисээр хүрээлэгдэж байсан ч Камакүрагийн үе буюу XIII зууны сүүлийн хагаст Монголын Юан улсын үед Хубилай хаан Японтой харилцаа тогтоохыг оролдож 1268-1272 онд зургаан удаа элч илгээсэн² юм. Японы засгийн газар хариу үл явуулсан тул Хубилай хааны цэрэг 1274 онд довтлон Цүшима, Ики арлыг эзэлж Кюүшюү арлын хойд хэсэгт тулж очсон боловч далайн хүчтэй шуурганы улмаас ухрахад хүрчээ. Хоёр дахь удаагаа 1281 онд хийсэн довтолгоо ч амжилтанд хүрээгүй юм. Камакүрагийн засгийн газар эх нутгаа харийн довтолгооноос хамгаалах нэрийн дор өөрийн байр суурийг батжуулан,

* У.Загдцэсэм - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистрант

эзэн хааны мэдлийн сүмийн эзэмшил газрын хамгаалалтын цэргүүдийг ч мэдэлдээ шилжүүлэн авчээ.³ Гэсэн хэдий ч улсын сангаас их хэмжээний хөрөнгө хүч зарцуулан газар нутгаа хамгаалж, бас гавьяа байгуулсан цэргүүдэд шан харамж хүртээсэн зэргээс болж шёогүний засгийн газар хямралд орсон байна. Нөгөөтэйгүүр Юан улсын довтолгооны үеэр япончуудын дунд эх орноо гэсэн үзэл төлөвшин тогтсон гэдэг.

XVI зууны эхний хагаст улс орныг нэгтгэх хандлага хүчтэй болж ирж, энэхүү үйл хэргийг Ода Нобунага эхэлсэн бөгөөд түүний дараа Тоётоми Хидэёши улс орныг үндсэнд нь нэгтгэж чаджээ.

Улмаар 1603 онд шёогүн Токүгава Иэясү засгийн эрхэнд гарснаас хойш түүний үе залгамжлагчид 1867 он хүртэл төр барьжээ.⁴ Токүгавагийн үед улсын нийслэлийг Эдо хот одоогийн Токиод байгуулсан нь өнөөдрийг хүртэл Японы улс төр, эдийн засгийн төв болж уламжлагдан иржээ. Эдо үеийн нэг онцлог бол Токүгава овгийн шёогүн нарын төр барьж байх үед хаалттай бодлого явуулж, Япон орон 200 гаруй жилийн турш хаалттай орон байсанд оршино. Хаалттай орны бодлого явуулах болсон гол шалтгаан нь христосын шашинт улсуудын нөлөө улс орны аюулгүй байдалд нөлөөлнө гэж үзэх болсонтой холбоотой байна. Хаалттай бодлого явуулснаар японы уламжлалт соёл, эдийн засаг хөгжихөд үүрэг гүйцэтгэсэн ч гэж үздэг.

Япон оронд дээр өгүүлсэнчлэн 700-гаад жилийн турш үргэлжилсэн Шёогүний засаглал Америк Европын улс орнуудын шахалтаар 1867-1868 оны үед унаж Эзэн хаан Мэйжи засгийн эрхэнд эргэн гарснаар улс төр, нийгмийн тогтолцоо, ард түмний ахуй амьдралд асар их өөрчлөлт гарсан⁵ юм. Энэ үеийг Японы түүхэнд “Мэйжи ишин” буюу Мэйжигийн шинэчлэл гэж нэрлэдэг. Энэ үйл явдлыг үндсэндээ хөрөнгөтний хувьсгал байсан гэж судлаачид үздэг. Мэйжийн засгийн газар Японы ганцаардмал байдлыг эцэс болгон үйлдвэржсэн барууныхныг гүйцэхийн тулд хөрөнгөт нийгмийн шинж чанартай хэд хэдэн өөрчлөлтийг хийж эхэлжээ. Үүнд: “улс орноо баян чинээлэг болгох, цэрэг армия хүчирхэг болгох” бодлого явуулж, Японд капитализм хөгжих үндэс суурийг тавьж, улмаар энэ бодлого Япон улс орчин үеийн капиталист орон болж хөгжихөд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм.

Улс төрийн хувьд гарсан томоохон өөрчлөлт нь “Эзэн хаант улсын үндсэн хууль 1889 онд батлагдан гарч, улмаар Эзэн хаант улсын анхны парламент байгуулагдсан”⁶ явдал байлаа. “1890 онд анхны сонгуулийн хууль батлагдаж 25-аас дээш насны эрэгтэй хүн 15 иен төлснөөр сонгуульд оролцох эрхтэй болж”⁷, эмэгтэйчүүд сонгуулийн эрхгүй үлдэв.

Эзэнт улсын үндсэн хуульд зааснаар Эзэн хаан үлэмж эрх эдлэх болсон байна. Эзэнт улсын парламент нь Зөвлөхүүдийн танхим, Төлөөлөгчдийн танхимаас бүрдэж, Зөвлөхүүдийн танхим нь шийдвэр гаргах гол давуу эрхтэй байсан юм. Зөвлөхүүдийн танхим нь эзэн хааны угсааны язгууртан ноёдоос бүрддэг байв. Тэр үеийн улс төрийн тогтолцоо нь Эзэн хаан төвт тогтолцоо байсан гэж болно.

Япон улс АНУ, Европын орнуудтай хийсэн эрх тэгш бус олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийг засамжлан залруулах, засаг захиргааны хуваарийг өөрчлөх бодлого явуулж, 1871 оноос орчин үеийн мужийн хэлбэрт оруулсан юм. Түүнчлэн 1872 онд бүх нийтээр цэргийн алба хаах хууль гарган, хуурай замын цэргийг Германы, усан замын цэргийг Английн жишгээр зохион байгуулах чиглэл барьсан байна. Иргэний болон эрүүгийн хуулийг Францын, анагаах ухааныг Германы жишгээр зохион байгуулж тухайн үеийн Европ, Америкийн хөгжилтэй орнуудын сайн талыг хуулан авсан гэдэг. Мөн газрыг тариачдад хувьд нь эзэмшүүлэн албан татвар авч байхаар газрын шинэтгэлийг 1873 онд явуулжээ.

Мэйжийн засгийн газраас явуулсан шинэтгэлийн тууштай бодлогын дүнд XIX-XX зууны зааг болоход Японд аж үйлдвэрийн хувьсгал өрнөж, капиталист хөгжлийн шатанд орсон байна.

XX зууны эхэн үе нь дэлхий дахины олон улсын байдалд ихээхэн өөрчлөлт гарсан үе байсан бөгөөд империалист гүрнүүд нөлөөнийхөө хүрээг тэлж бодлого явуулж, Япон улс ч 1940 онд Герман, Итали улсуудтай цэргийн эвслийн гэрээг байгуулан холбоотон улс болж улмаар 1941 оны 12-р сард Номхон далайд АНУ, Английн эсрэг дайнд орсон юм. Дэлхийн II дайн Европод дууссаны дараа ЗХУ, АНУ, Английн холбоотон орнууд Японы эсрэг дайнд орж, Японы арми 1945 оны 9-р сард дайнд ялагдсанаа хүлээн үг дуугүй бууж өгснөөр дэлхийн II дайн төгсгөл болсон билээ.

Дэлхийн II дайны дараа Японы улс төрийн тогтолцоо үндсээрээ эрс шинэчлэгдсэн юм. Юуны өмнө ардчилсан шинэ Үндсэн хуулийг тогтоон хэрэгжүүлэв. Япон улсын Үндсэн хууль 1946 оны 11-р сард батлагдаж, 1947 оны 5-р сараас хүчин төгөлдөр үйлчилж эхэлжээ. Нийт 11 бүлэг 103 зүйлтэй, 1. Төрийн бүх эрх ард түмний гарт байна 2. Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэнэ 3. Дайнаас татгалзана гэсэн 3 гол зарчмыг үндэс болгосон⁸ юм. Япон улс энх тайванч гадаад бодлого явуулахаар хуульчилж, Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлд “дайнаас үүрд татгалзана” хэмээсэн нь дэлхийн өөр аль ч улсын Үндсэн хуульд байдаггүйгээрээ онцлог энх тайваныг дээдэлсэн хууль болсон гэгддэг. Цэрэг армийн хувьд зөвхөн өөрийгөө хамгаалах хүчинтэй байхаар

шийдвэрлэжээ. 1946 онд сонгуулийн шинэ хууль батлагдан эмэгтэйчүүдэд сонгуулийн эрх олгож, 20 наснаас дээших япон улсын бүх иргэн сонгуульд оролцох эрхтэй болсноор урьдын “зөвхөн эрэгтэйчүүд сонгуульд оролцох эрхтэй байсан”⁹ хуучин тогтолцоог халж сонгуулийн ардчилсан тогтолцоо бүрдсэн юм.

Япон улсын өнөөгийн улс төрийн тогтолцоо нь шинэ Үндсэн хуулийн дагуу бүрэлдэн тогтжээ. Японы улс төрийн тогтолцоо нь Эзэн хаан, Парламент, Засгийн газар, Шүүхийн байгууллагаас бүрддэг.

Японы Эзэн хаан, хаант засаглалын тухайд Япон улс нь эдүгээ Ази тивд оршиж буй хаант засаг бүхий зургаан орны нэг нь бөгөөд манай гариг дээр үе залгамжилсан Эзэн хаант засгаас хамгийн эртний түүхтэй орон юм. Эзэн хаант тогтолцоо нь домгийн Нарны дагина Амагэрасугаас улбаалан улмаар “660 онд анхны Жинмү Тэнноо төр улсыг байгуулж хаан ширээнд суусан үеэс хойш эдүгээ хүртэл 125 эзэн хаан үе залгамжилж”,¹⁰ өнөөгийн 125 дахь эзэн хаан Акихито хүрсэн гэж үздэг.

Шинто шашны охин тэнгэр Амагэрасүгийн унаган удам, амьд бурхан хэмээн шүтэгдэж ирсэн Эзэн хаан Хирохито дэлхийн II дайны дараа 1946 онд дээд тэнгэрийн язгууртан гэдгээсээ тагталзан “Нийтийн адил эгэл хүн” хэмээн өөрийгөө зарласан бөгөөд засаглалын дээд эрх нь Үндсэн хуулиар ард түмний гарт шилжсэн юм. Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд “Эзэн хаан нь төр улс болон ард түмнийхээ эв нэгдлийн билэг тэмдэг” гэж заасан. Эдүгээ Эзэн хаан Парламентийн нэр дэвшүүлснээр Ерөнхий сайд болон дээд шүүхийн ерөнхий шүүгчийг батламжлах, парламентийн чуулганыг зарлан хуралдуулах, бүх нийтийн сонгуулийг зарлах зэрэг үйл ажиллагаа, хууль, зарлиг, гэрээ батламжийг зарлан тунхаглах, бүрэн эрхт элчин сайд нарын жуух бичгийг батлах, гадаадын элчин сайд нарыг хүлээн авах, гавьяа шагнал гардуулах зэрэгт оролцдог байна.

Тийнхүү түүхийн хугацаанд эзэн хааны эрх мэдэл нэгэн үе өсч, нэгэн үе буурч иржээ.

Дээр өгүүлсэнчлэн Японы парламентийн засаглалын тухайд Япон улс нь парламентийн өвөрмөц түүхтэй орон юм. Японд Мэйжигийн 22 дугаар он буюу 1889 онд анхны Парламенттай болж, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бол Шёовагийн 22 дугаар он буюу 1947 онд өнөөгийн Парламент Үндсэн хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

Япон улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд “Японы үндэсний их хуралдаан болох Парламент нь төрийн эрх барих дээд байгууллага, төрийн хууль тогтоох цорын ганц байгууллага юм”¹¹ гэж тодорхойлсон байдаг. Мөн Үндсэн хуулийн 42 дугаар зүйлд “Парламент нь

Төлөөлөгчдийн танхим, Зөвлөхүүдийн танхимаас бүрдэж үйл ажиллагаагаа явуулна”¹² гэж заасан ба хуулийн төсөл, улсын төсөв хэлэлцэх, гэрээ хэлэлцээрийг батлах, Засгийн газрын тэргүүн Ерөнхий сайдыг нэр дэвшүүлэх зэрэгт хоёр танхим санал зөрөлдсөн тохиолдолд Төлөөлөгчдийн танхимын саналаар тогтдог байна.

Японы Парламентийн үйл ажиллагаа нь Үндсэн хууль, 1947 онд батлагдсан “Төлөөлөгчдийн танхимын дүрэм”, 1949 онд батлагдсан “Зөвлөхүүдийн танхимын дүрэм”-ийн дагуу хэрэгждэг.

2000 онд өөрчлөгдсөн олон нийтийн сонгуулийн тухай хуулиар Төлөөлөгчдийн танхим нь 480 гишүүний суудалтай 4 жилийн хугацаатай сонгогддог болсон ба 25 наснаас дээшхи Япон улсын иргэн сонгогдох эрхтэй. Зөвлөхүүдийн танхимын хувьд 242 гишүүний суудалтай, 6 жилийн хугацаатай сонгогддог бөгөөд 30 наснаас дээшхи Япон улсын иргэн сонгогдох эрхтэй байдаг байна. Төлөөлөгчдийн танхим хугацаанаасаа өмнө бүрэн бүрэлдэхүүнээрээ тарах тохиолдол байдаг бол Зөвлөхүүдийн танхим хугацаанаасаа өмнө бүрэн бүрэлдэхүүнээрээ тардаггүй 3 жил тутамд гишүүдийн тэн хагас нь шинэчлэгдэн сонгогдож байдаг.

Төлөөлөгчдийн танхим татан буулдсан үед Засгийн газраас онцгой тохиолдолд Зөвлөхүүдийн танхимыг зарлан хуралдуулж, хууль зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх эрх олгодог.

Японы Парламент хоёр танхимтайн давуу тал нь олонхийн саналд шүүмжлэлтэй хандах, нарийн нягт хэлэлцэх, хоёр танхим хоорондын хүчний тэнцвэрийг хадгалах, нөгөө талаас нэг танхимын үйл ажиллагаа тасалдахад хүрвэл нөгөө танхимд асуудлыг үргэлжлүүлэх боломжтой.

Парламентийн гишүүдийн дотроос Ерөнхий сайдыг томилдог ба Ерөнхий сайд нь Засгийн газрыг эмхлэн байгуулдаг. Засгийн газар 20 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулдаг байна.¹³

Япон улсын Засгийн газар буюу Сайд нарын танхимын үйл ажиллагааг Үндсэн хууль, Засгийн газрын тухай хуулиар зохицуулдаг.

Дэлхийн II дайны дараа японы цэрэг дайнч байдлыг сэргээхгүйн тулд Сайд нарын танхимын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж дотоод явдлын сайд, хуурай замын болон далайн цэргийн сайдын албан тушаалыг үгүй болгожээ.

Японы засаглалын гурван хэлбэр болох парламент, засгийн газар, шүүх байгууллагууд хоорондоо хэрхэн холбоо хамааралтай үйл ажиллагаагаа явуулдаг талаар өгүүлье.

Парламент, Засгийн газрын харилцан хамаарал: Засгийн газрыг Парламентийн гишүүдийн дотроос томилдог ажээ. Өөрөөр хэлбэл Япон улсын Засгийн газар нь гүйцэтгэх засаглалын эрхээ хэрэгжүүлэхдээ Парламенттэй нягт холбоотой байж, түүний өмнө тодорхой хариуцлага хүлээдэг /Үндсэн хуулийн 67-р зүйл/ байна. Парламент нь Засгийн газрын Ерөнхий сайдыг Парламентийн гишүүдийн дотроос нэр дэвшүүлдэг, мөн Засгийн газрын гишүүдийн талаас илүү хувь нь Парламентийн гишүүдээс бүрддэг /Үндсэн хуулийн 66, 67-р зүйл/ ажээ. Ийнхүү Парламентад олонхи суудлыг авсан нам, эвсэл Засгийн газрыг байгуулж, Парламент Засгийн газрын үйл ажиллагааны нэгдлийг зохицуулдаг аж. Төлөөлөгчдийн танхим нь Засгийн газарт итгэл үл үзүүлэх шийдвэр гаргах эрхтэй бөгөөд ийм тохиолдолд Засгийн газрын тэргүүн Төлөөлөгчдийн танхимыг тараах эрхтэй байдаг. Хууль тогтоох эрх Парламентад хадгалагдах бөгөөд Засгийн газар нь хуулийн төслийг өргөн барих эрхтэй байдаг.

Парламент, Шүүх засаглалын харилцан хамаарал: Шүүх нь Парламентаас батлан гаргасан хууль Үндсэн хуулийн агуулгад нийцэж буй эсэхийг хянан үзэх эрхийг эдэлдэг. Харин Парламентийн хувьд Дээд шүүхийн ерөнхий шүүчийг ажил үүргээс нь халах, шүүх хурлыг явуулах Парламентийн гишүүдээс бүрдсэн Импичмент /impeachment/-ийг байгуулдаг.

Засгийн газар, Шүүхийн харилцан хамаарал: Засгийн газрын тогтоол, түүнд үндэслэн Засгийн газраас гаргаж буй шийдвэр, дүрэм, журам Үндсэн хуулийн агуулгад нийцэж байгаа эсэхийг шүүхээс хянан үздэг. Харин Засгийн газрын тэргүүн нь бүрэн эрхийнхээ дагуу Дээд шүүхийн даргыг нэр дэвшүүлж, бусад шүүгчдийг томилдог байна.

Ийнхүү Парламент, Засгийн газар, Шүүхийн хооронд харилцан хамаарал, харилцан хяналт, харилцан тэнцвэр бүхий үйл ажиллагааны тогтолцоо хэрэгжиж, энэ тогтолцоонд Парламент нь Төрийн эрх барих дээд байгууллагын байр суурийг хадгалж байдаг ажээ.

Эцэст нь тэмдэглэхэд дэлхийн II дайны дараа Японы улс төрийн тогтолцоонд гарсан үндсэн өөрчлөлт нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн засаглалын гурван хэлбэрийн бие даасан байдлыг тунхаглан тодорхойлж, харилцан хяналттай үйл ажиллагаа явуулдаг тогтолцоо бий болсонд оршино. Мөн Эзэн хааны хэмжээгүй эрхийг хуулиар хязгаарлан, эзэн хаан нь ард түмэн улс орныхоо эв нэгдлийн билэг тэмдэг нь болсон байна. Парламент нь засаглалын эрхийг хэрэгжүүлж,

түүнд шүүх тогтоох байгууллага нь шүүмжлэлтэй ханддаг ардчилсан тогтолцоог бий болгожээ. Ийнхүү Японы улс төрийн тогтолцоо нь түүхийн явцад өөрчлөгдөн шинэчлэгдэхдээ өөрийн өвөрмөц уламжлалаа ч мөн хадгалж ирсэн нь харагдаж байна.

Үүнийг өөрийн уламжлалт түүх, соёлыг нандигнан хадгалж чаддаг, мөн гадны дэвшилтэт соёлыг хүлээн авч өөрийн болгохдоо гарамгай гэгддэг Японы ард түмний үндэсний өвөрмөц онцлогтой ч холбон үзэж болох болов уу.

Ишлэл зүүлт

1. JAPAN AS IT IS Gakken, 2002, тал 40
2. Т.Мөнхцэцэг “XIII-XIV зууны Монгол Японы харилцаа” УБ, 2004
3. Т.Мөнхцэцэг “Япон дахь Монголын түүхийн судалгаа” УБ, 2000, тал 39.
4. “Япон орон япончууд” УБ, 1991, тал 9.
5. Шибата Рёотаро “Мэйжи хэмээх төр улс” УБ, 2000, тал 123.
6. Ишида Мицүёоши. “Сэйжи но шикүми” Токио, 2004, тал 56.
7. “Нихон но аюми” Чюүкёү шүппан, Токио, 1992, тал 83.
8. “Япон улсын Үндсэн хууль” “Тайякү нихон житэн”, Токио, 1998, тал 792.
9. “Нихон но аюми” Чюүкёү шүппан, Токио, 1992, тал 83.
10. “Япон орон япончууд” УБ, 1991, тал 13.
11. “Япон улсын Үндсэн хууль” “Тайякү нихон житэн”, Токио, 1998, тал 796.
12. Мөн тэнд
13. Ишида Мицүёоши. “Сэйжи но шикүми” Токио, 2004, тал 75.